



АУДИТЫН КОД: САГ-2017/30/СТА-ТЕЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу:

Цахим хуудас: www.audit.mn

Санхүүгийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг

Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер Я.Самбууням

Утас: 260512 Цахим хаяг: sambuunyamy@audit.gov.mn

Аудитор Р.Цолмон

Утас: 260512 Цахим хаяг: tsolmonr@audit.gov.mn

АГУУЛГА

1	Аудитын гэрчилгээ	2
2	Аудитын тайлан	4
2.1	Оршил	4
2.2	Аудит хийх хууль, эрх зүйн үндэслэл	4
2.3	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.4	Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	6
2.5	Дотоод хяналт	7
2.6	Төсвийн орлого, зардлын гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	7
2.7	Шилэн дансны мэдээлэл	8
2.8	Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар	8
2.9	Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл	9
2.9.1	Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн талаар	9
2.9.2	Төсвийн гүйцэтгэлийн талаар	9
2.9.3	Авлага, өглөгийн талаар	9
2.9.4	Хөгжлийн банкны гэрээний талаар	10
2.9.5	Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн талаар	10
2.9.6	Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн талаар	11
2.9.7	Хөрөнгө оруулалтын талаар	11
2.9.8	Цалингийн талаар	11
2.9.9	Өмнөх зөвлөмжийн биелэлтийн талаар	11
2.9.10	Алдаа, зөрчлийн талаар	12
2.9.11	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны харьяа байгууллагуудын 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар гарсан зөрчлүүдийн талаар	12
2.10	Анхаарал татахуйц бусад чухал асуудал	14
2.11	Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд	14
2.12	Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл	14
2.13	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	14
2.14	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	15
2.15	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	15
3	Менежментийн захидал	16
4	Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл	29
4.1	Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан	29
4.2	Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан	30
4.3	Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн нэгтгэсэн тайлан	32
4.4	Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний нэгтгэсэн тайлан	33
4.5	Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн нэгтгэсэн тайлан	35

1 Аудитын гэрчилгээ



**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу 3, Засгийн газрын IV байр,
Утас: 26 04 37, Факс: (976) 6226 3230,
E-mail: info@audit.gov.mn, http://www.audit.mn

2017.04.25 № 770

танай _____-ны № _____-г

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.3-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн нэгтгэсэн тайланг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Санхүүгийн тайлангууд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (УСНББОУС), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Санал дүгнэлтийн үндэслэл

Бид аудитыг Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан "Санхүүгийн тайлангийн аудитын журам"-ын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журмын шаардлага нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэх явдал болно.

Аудитаар санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем, тэдгээрийг дэмжих нотлох зүйлийг сорилын үндсэн дээр шалгаж, удирдлагын хийсэн томоохон тооцооллыг үнэлж цэгнэн, санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулгыг үнэлсэн.

Аудитын явцад хэрэгжүүлсэн горим, сорилоор олж авсан нотлох зүйлс санхүүгийн нэгтгэсэн тайланд санал дүгнэлт өгөх хангалттай үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд:

- Тариалан эрхлэлтийг дэмжих сан 2008 онд үүссэн улаан буудайн өглөг 24,000.0 сая төгрөгийг Сангийн яамтай тооцоо нийлж, баталгаажуулаагүй байна.

\\10.10.10.20\Bichig_Kherel\Yawsan_Bichig\2017\0425SAG42.Docx

070228


Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын
2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит

- Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн санхүүгийн тайланд тусгасан нийт 77,419.9 сая төгрөгийн авлагын 68.8 хувь буюу 53,290.2 сая төгрөгийн авлагыг баталгаажуулаагүй, 85.8 хувь буюу 66,397.3 сая төгрөгийн авлага нь хугацаа хэтэрсэн авлагууд байна.
- Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн 2011-2015 онд үүссэн эргэн төлөлтийн 30,045.9 сая төгрөгийн зээл буцаан төлөгдөх нь тодорхойгүй.
- Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас “Аж үйлдвэрийн цогцолбор” ТӨХК-д 1,500.0 сая төгрөгийн зээлийг хүүгүй, барьцаа хөрөнгөгүйгээр олгосон.
- Үндэсний аудитын газраас урьд онд хийсэн аудитаар өгсөн 102,586.6 сая төгрөгийн 4 зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, 3,000.0 сая төгрөгийн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй байна.

Хязгаарлалттай санал дүгнэлт

Дээр дурдсан алдаа зөрчлийн санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөллийг эс тооцвол Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн, шударга илэрхийлсэн байна.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР



Д. ХҮРЭЛБААТАР

2 Аудитын тайлан

2.1 Оршил

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2016 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайланг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд П.Сэргэлэн танд танилцуулж байна.

Энэхүү тайланд танай санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, залруулаагүй материаллаг биш алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Менежментийн захидалд үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, зардал, төсвийн гүйцэтгэл, зээл олголт, зээлийн эргэн төлөлт, хууль эрх зүйг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитын төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулан Санхүүгийн тайлангийн аудитын удирдлагын системд оруулсан бөгөөд аудитад баримталсан стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

2.2 Аудит хийх хууль, эрх зүйн үндэслэл

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Аудитыг Төрийн аудитын тухай, Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт (УСНББОУС), түүнд нийцүүлэн гаргасан улсын төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны удирдлага санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын баталсан холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн санхүүгийн тайлангийн аудитыг 2017 оны 4 дүгээр сарын 05-наас 2017 оны 4 дүгээр сарын 24-ны хооронд хийхээр төлөвлөн Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газрын аудитор Р.Цолмон хэрэгжүүлэв.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг 2017 оны 4 дүгээр сарын 07-нд Үндэсний аудитын газарт ирүүлсэн боловч Төсвийн тухай хуулийн цаглабарт хугацааг 2 хоногоор хэтрүүлсэн байна.

Үндэсний аудитын газар аудитыг батлагдсан төлөвлөгөө, хөтөлбөрийн хүрээнд гүйцэтгэж, аудитын тайланг 2017 оны 4 дүгээр сарын 25-нд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдад гардуулна.

2.3 БАЙГУУЛЛАГЫН ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА, ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны үйл ажиллагааны эрхэм зорилго нь салбарын бодлогыг оновчтой тодорхойлж хэрэгжүүлэх замаар түүхий эдийн нөөцийг зохистой ашиглах, импортыг орлох, экспортын баримжаатай бүтээгдэхүүний үйлдвэрлэл, үнэ цэнийн сүлжээг хөгжүүлэх, үйлдвэрлэлийн орлого, бүтээмжийг өсгөн өрсөлдөх чадварыг дээшлүүлэн салбарын эдийн засгийн өсөлтийг тогтвортой нэмэгдүүлэх, хүн амыг эрүүл, аюулгүй, шим тэжээллэг хүнс, эрүүл ахуй, хэрэглээний шаардлага хангасан хувцас, хэрэгслээр хангах нөхцөлийг бүрдүүлэхэд оршино.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэр, жижиг дунд үйлдвэр, хоршоо, дотоод худалдаа, үйлчилгээний салбарыг олон улсын зах зээлд өрсөлдөхүйц хөгжлийн шинэ шатанд гаргаж эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлнэ гэж энэ байгууллагын зорилтыг тодорхойлсон байна.

Дээрх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.8-д Засгийн газрын гишүүн холбогдох төрийн захиргааны төв байгууллагын болон түүнд хууль тогтоомжоор харьяалуулсан бусад байгууллагын төсвийн ерөнхийлөн захирагч байна гэж заасны дагуу төсвийн ерөнхийлөн захирагчийн үүргийг гүйцэтгэж байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчтай холбоотой хууль эрх зүйн баримт бичгийг судалсан бөгөөд байгууллагатай холбоотой Төсвийн тухай хууль, Тариалангийн тухай хууль, Үйлдвэрлэлийг дэмжих тухай хууль, Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хуулиудыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны үйл ажиллагааны талаар ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.

Тайлант онд МУ-ын Засгийн газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5.13-т “Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд хөнгөн үйлдвэрийн бодлогын асуудал, жижиг, дунд үйлдвэрийн хөгжлийн асуудал, дотоод худалдаа, үйлчилгээний бодлого, зохицуулалтын асуудлын хүрээний бодлогын төлөвлөлт, боловсруулалт, удирдлага, зохицуулалт болон дүн шинжилгээ хийх, үнэлгээ өгөх ажлыг эрхэлнэ” гэсэн заалтын дагуу Аж үйлдвэрийн яам татан буугдаж Аж үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2016 оны 03/2157 дугаар албан

бичгээр дээрх яаманд ажиллаж байсан 36 албан хаагчийг шилжүүлсэн боловч тус яамны бүтэц, чиг үүргийн дагуу ажлын байраар 17 албан хаагчийг ханган ажиллуулж байна.

Хүнс, хөдөө, аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар батлагдсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын дагуу гаргасан байна.

2.4 Аудитын шалгуур үзүүлэлт, АРГА ЗҮЙ, ХЭРЭГЖҮҮЛСЭН ГОРИМ СОРИЛ, ТҮҮНИЙ ҮР ДҮН

Аудит хийхэд Аудитын олон улсын стандарт, Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт 1000 – 1810 буюу Санхүүгийн аудитын удирдамж, Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

Аудитаар Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санал дүгнэлт өгөх зорилгоор тэдний бэлтгэсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн дансдын уламжлалт болон хяналтын эрсдэлийг үнэлснээс гадна Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа.

Дотоод хяналтын талаарх гол асуудал, дүгнэлтийг энэ тайлангийн 2.5-д үзүүлэв.

Санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын 7 чиглэлээр түүвэрчилсэн байдлаар аудитын 6 горим, сорил гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2016 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нэгтгэгдсэн байгууллагуудын аудитын дүгнэлт, өгсөн зөвлөмж, төлбөрийн акт, албан шаардлага, сахилгын шийтгэл, өгсөн зөвлөмж, залруулсан алдаа зөрчлийг нэгтгэн шалгалаа.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2016 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланд ХХААХҮС-ын шууд харьяа 8 байгууллага, орон нутаг дахь Хүнс, хөдөө аж ахуйн газар, Нийслэлийн мал эмнэлгийн газар зэрэг 22 байгууллага, Засгийн газрын тусгай сан 3, 8 төсөл, хөтөлбөр, Төрийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар 4 нийт 45 байгууллагын санхүүгийн тайлан нэгтгэгдсэн байна.

Тайлант онд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын санхүүгийн тайланд нэгтгэгдэж байгаа 20 байгууллагад төрийн аудитын байгууллага, 10 байгууллагад хараат бус аудитын компани, 7 байгууллага нь аудитын түүвэрт хамрагдсан, 4 байгууллагад аудитын итгэл үзүүлсэн, үлдсэн 4 байгууллагад аудит хийгдээгүй байна.

Эдгээр байгууллагад хийсэн хэрэгжүүлсэн горим сорилын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй зарим гол асуудлыг энэ тайлангийн 2.9 дэх заалтад хураангуйлан тэмдэглэв.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи,

бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд эрсдэл бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэн аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүүгийн нэгтгэсэн тайлан бэлтгэхэд төсвийн байгууллагын санхүүгийн тайлан нэгтгэдэг “Э-тайлан” програм хангамж ашиглажээ.

2.5 Дотоод хяналт

Бид санхүүгийн нэгтгэсэн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын багцын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт хэвийн гэж үзлээ.

Аудитын явцад төлөвлөсөн горим сорилын дагуу дотоод аудитын албаны үйл ажиллагаатай танилцаж, тэдний үүрэг чиглэл, үйл ажиллагааны төлөвлөлт, гүйцэтгэл, үр дүнгийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хавсаргалаа.

Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1-д “Төсвийн ерөнхийлөн захирагч бүр хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр, төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт, шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэсэн дотоод аудитын албыг байгуулж, дотоод аудитор ажиллуулна”, мөн ЗГ-ын 2015 оны 483 дугаар тушаалаар баталсан Дотоод аудитын дүрмийн дагуу Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар 11 албан хаагчидтайгаар үйл ажиллагаагаа явуулж байна.

Тайлант онд МУ-ын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр дэх хүнс, хөдөө аж ахуйн салбарын зорилтуудыг хэрэгжүүлэх арга хэмжээний биелэлтийн явцын хяналт-шинжилгээ, үнэлгээ, Ерөнхийлөгчийн зарлиг, Улсын Их Хурлын тогтоол, МУ-ын Засгийн газрын тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийн явцад хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээ, Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2016 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд хүнс, хөдөө аж ахуйн салбарын хамааралтай асуудлаар тусгагдсан зорилт, арга хэмжээнүүдийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээ Улсын мал эмнэлэг ариун цэврийн төв лаборатори, Нийслэлийн мал эмнэлгийн газар, “Ногоон алт төсөл”-ийн үйл ажиллагаа, Хөдөө аж ахуйн халх гол үндэсний бүтээн байгуулалтын бүсийн захиргаа, Мал хамгаалах сан, Дархан-Уул аймаг дахь “Үр тариа хадгалах 36.0 мянган тонн багтаамжтай, төмөр бетон хийцтэй элеватор” худалдан авах үйл ажиллагаанд тус тус дотоод аудит хийж ХХААХҮС-ын 2016 оны А-13 дугаар тогтоолоор баталсан дотоод аудитын хорооны тогтоолоор шалгалтын үйл ажиллагаанд хийсэн аудитын дүнг хэлэлцүүлж, аудитын хорооны тогтоолыг тус тус баталсан байна.

2.6 Төсвийн орлого, зардлын гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны 2016 оны батлагдсан төсвийн сар, улирлын хуваарийг батлагдсан төсвийн хүрээнд Төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжигдсэн ба төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, төсвийн санхүүжилтийн

гүйцэтгэлийг хангах, төсвийн зардлын төрөл зүйлээр хуваарилан гүйцэтгэлд нь хяналт тавин ажилласан байна.

Монгол Улсын 2016 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 2016 оны 9 дүгээр сард батлагдсан хуулиар Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн сайдын багцыг 201,935.3 сая төгрөгөөр батлагддаг боловч дотоодын эх үүсвэрээс олгосон зээлийн эргэн төлөлтөөр Тариалан эрхлэлтийг дэмжих сан 24,000.0 сая, Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих сангийн дамжуулан зээлдүүлсэн зээлийн эргэн төлөлт 52,000.0 сая төгрөгөөр, нийт 76,000.0 сая төгрөгөөр төлөгдөх дүнгээр хорогдуулж төсвийн гүйцэтгэлийн нэгтгэсэн тайланд төлөвлөгөөг 125,935.3 сая төгрөгөөр тусгасан байна.

Төсвийн гүйцэтгэлийн нэгтгэсэн тайлангийн гүйцэтгэлийг 142,178.4 сая төгрөгөөр тусгасан боловч Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих сангийн дамжуулан зээлдүүлсэн зээлийн бондын эргэн төлөлтийг 51,870.0 сая төгрөгийг нэмэгдүүлбэл жинхэнэ гүйцэтгэл 194,048.4 сая төгрөгийн гүйцэтгэлтэй байна.

Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн сайдын багцад 2016 онд 125,935.3 сая төгрөгийн төсөв батлагдан 142,178.4 сая төгрөгийг зарцуулж батлагдсан төсвийг 16,243.1 сая төгрөгөөр хэтрүүлсэн мэт харагдаж байгаа нь дээрх нийт 76,000.0 сая төгрөгөөр төсөв болон дамжуулан зээлдүүлсэн зээлээс эргэн төлөгдөх дүнгээр хорогдуулж бичсэнээс шалтгаалжээ.

2.7 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн дагуу төсвийн болон улс, орон нутгийн өмчийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах зорилгоор төсвийн удирдлагын шийдвэр, үйл ажиллагаа ил тод, нээлттэй, ойлгомжтой байх, түүнд олон нийт хяналт тавих мэдээллийн тогтолцоонд хангах хүрээнд тус яам өөрийн цахим хуудсаар <http://shilendans.gov.mn/agency/1025> байршуулсан байна.

Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу албан тушаалтан хуулийн хэрэгжилтэд хяналт тавьж байгаа эсэхийг аудитаар анхаарч үзлээ. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагад хамаарах харьяа байгууллагууд шилэн дансны сайтад бүрэн хамрагдсан бөгөөд шилэн дансны цахим хуудсанд 2016 онд нийт 6620 мэдээлэл байршуулахаас 6456 мэдээлэл байршуулж хуулийн хэрэгжилт 98.2 хувьтай байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчид харьяалагдах байгууллагууд батлагдсан төсөв, дараа жилийн төсвийн төсөл, тендерийн ерөнхий мэдээлэл, худалдан авах ажиллагааны тайлан зэрэг мэдээллүүдийг дутуу байршуулсныг аудитын явцад илрүүлж байршуулсан.

2.8 Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 10 эрсдэл тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 6 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Хэрэгжүүлсэн горим сорилын үр дүнг гүйцэтгэлийн үе шатны “Төлөвлөсөн горим, сорилуудыг хэрэгжүүлж, үр дүнг аудитын чиглэл тус бүрээр баримтжуулах” гэсэн үе шатны ажилд хамааруулан ТАБ-СТА-В-3 маягтаар данс тус бүрээр баримтжуулсан болно.

Дээрх горим сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн зарим зөрчилтэй асуудлыг энэ тайлангийн 2.9-д хураангуйлан тэмдэглэв.

2.9 Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл

2.9.1 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн талаар

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2016 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдэж байгаа байгууллагуудын 30 байгууллага нь аудитад хамрагдсан бөгөөд 25 байгууллагад “Зөрчилгүй”, 4 байгууллагад “Хязгаарлалттай”, 1 байгууллагад “Сөрөг” санал дүгнэлт авсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 2.3-т Төсвийн ерөнхийлөн захирагч түүний бүрэн эрхийг “Өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах” гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

“Хязгаарлалттай” санал дүгнэлт авсан байгууллагууд:

- Тариалан эрхлэлтийг дэмжих сан;
- Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих сан;
- Малын удмын сангийн үндэсний төв;
- Хөдөө аж ахуйн бирж;

“Сөрөг” санал, дүгнэлт авсан байгууллага:

- Говь-Алтай аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1-д “.....санхүүгийн тайлангийн аудитаар хязгаарлалттай, сөрөг санал, дүгнэлт авсан.....албан тушаалтанд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлагыг Төрийн аудитын байгууллагаас эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ” гэсэн заалтыг үндэслэн “Хязгаарлалттай”, “Сөрөг” аудитын дүгнэлт авсан байгууллагуудын холбогдох албан тушаалтнуудад хариуцлага тооцох талаар албан шаардлага өгөх.

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар нийт 548,043.2 сая төгрөгийн алдаа зөрчил илэрсний 13.4 сая төгрөгийн зөрчилд 4 төлбөрийн акт, 91.2 сая төгрөгийн зөрчлийг арилгах 4 албан шаардлага өгсөн бөгөөд аудитын явцад 28,214.8 сая төгрөгийн алдааг залруулж, 131.2 сая төгрөгийн зөрчил гаргасан 3 албан тушаалтанд хариуцлага тооцох санал өгч, 519,592.6 сая төгрөгийн алдаа, зөрчлийг арилгах талаар 77 зөвлөмж өгсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Аудитаар өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагыг хэрэгжүүлэх, биелүүлэн ажиллах талаар зөвлөмж өгөх.

2.9.2 Төсвийн гүйцэтгэлийн талаар

ХХААХҮС-ын тайлант оны санхүүгийн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлангаар батлагдсан төсвийг хэмнэлттэй зарцуулсан боловч бараа үйлчилгээний бусад зардлыг 17.0 сая, хөрөнгийн зардлыг 1,500.5 сая төгрөгөөр тус тус хэтрүүлэн зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Цаашид төсвийг батлагдсан хэмжээнд зориулалтын дагуу зарцуулах талаар зөвлөмж өгөх.

2.9.3 Авлага, өглөгийн талаар

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд урьд оноос авлага 12,513.0 сая төгрөгөөр, өглөг 38,116.2 сая төгрөгөөр тус тус өссөн байна. Энэ нь тус яамны удирдлага өөрийн харьяа байгууллагад бүртгэлээр тавих хяналт сул, авлага, өглөгийг цаг тухай бүрд баталгаажуулдаггүй, он дамжсан авлага, өглөгийг барагдуулах арга хэмжээ авч

ажиллаагүйгээс шалтгаалжээ.Тухайлбал:Тариалан эрхлэлтийг дэмжих сан нь 53,290.2 сая төгрөг буюу нийт авлагын 69.0 хувийг тооцоо нийлж баталгаажуулаагүй, 66,397.3 сая төгрөг буюу нийт авлагын 86.0 хувь нь хугацаа хэтэрсэн авлага байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Авлага, өглөгийг барагдуулах, тооцоо нийлж баталгаажуулах, цаашид авлага, өглөгийг нэмэгдүүлэхгүй байх талаар зөвлөмж өгөх.

2.9.4 Хөгжлийн банкны гэрээний талаар

Дархан Уул аймагт байрлах 36.0 мянган тонн багтаамжтай үр тариа хадгалах зориулалттай элеваторыг 15,995.0 сая төгрөгөөр худалдан авахад 7,995.0 сая төгрөгийг Хөгжлийн банкнаас санхүүжүүлж үлдэгдэл төлбөрийг тус яамны хөрөнгө оруулалтын зардлаас гаргасан бөгөөд Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгөнд бүртгэж авсан байна.

Гэвч шаардлага хангахгүй хөрөнгө бэлтгэсэн асуудлыг шийдвэрлэхээр Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн захирлын 2017 оны 01/27 дугаар албан бичгээр Цагдаагийн ерөнхий газарт шалгуулахаар хандсан байна. Иймд Сангийн яам, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Хөгжлийн банк хооронд байгуулсан төсөл санхүүжүүлэх ерөнхий нөхцөлийг тохиролцох гэрээг одоог хүртэл дүгнээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Дээрх асуудлыг судалж, холбогдох арга хэмжээ авах, Сангийн яам, Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Хөгжлийн банк хооронд байгуулсан төсөл санхүүжүүлэх ерөнхий нөхцөлийг тохиролцох гэрээг дүгнэх талаар зөвлөмж өгөх.

2.9.5 Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн талаар

Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн санхүүгийн тайлангийн 2016 оны жилийн эцсийн байдлаар өглөгөөр туссан 24,000.0 сая төгрөг нь Атрын 3 дахь аяны хүрээнд 2008 онд Монгол Улсыг хөгжүүлэх сангаас авсан 80.9 мянган тонн улаан буудайны улсын төсөвт төвлөрүүлэх ёстой үлдэгдэл төлбөр болно. Уг өглөгийг улаан буудайн хадгалалтын зардал, худалдах, худалдан авах үнийн зөрүүнээс үүссэн алдагдал, хэвийн хорогдол зэргийг тооцож Сангийн яамтай өнөөг хүртэл тулган баталгаажуулалт хийгээгүйгээс шалтгаалан барагдуулаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Сангийн яамтай МУХС-гийн улаан буудайн тооцоог хийж, улсын төсөвт төвлөрүүлэх, өглөгийг барагдуулах арга хэмжээ авах талаар зөвлөмж өгөх.

Тариалан эрхлэлтийг дэмжих сан 241.3 сая төгрөгийн үнэ бүхий 5 га-гийн дуслийн усалгааны системийг санхүүгийн тайланд тусгаагүй нь НББ-ийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.2-т “Бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлагыг Нягтлан бодох бүртгэлд заавал тусгана”, сонгон шалгаруулалтгүйгээр 1,978.0 сая төгрөгийн ургамал хамгаалалын бодис худалдан авсан нь ТБОНӨХБАҮХАТ хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-т “Энэ хуулийн 8.1.1-д “Босго үнээс дээш төсөвт өртөгтэй бараа, ажил, үйлчилгээг худалдан авахад энэ хуульд өөрөөр заагаагүй бол нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэнэ” гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Олж бэлтгэсэн хөрөнгийг холбогдох байгууллагын шийдвэрийг үндэслэн данс бүртгэлд тусгах, худалдан авалт хийхдээ холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулах, цаашид дээрх зөрчлийг давтан гаргахгүй байх талаар зөвлөмж өгөх.

2.9.6 Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн талаар

Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан нь 2009-2016 онуудад давхардсан тоогоор 775.200.0 сая төгрөгийг 7000 гаруй жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд хөнгөлөлттэй зээлийн үлдэгдэл сүү төслийн 167.2 сая, ахуй үйлчилгээний төв байгуулах 258.8 сая, түүхий эдийн төв байгуулах 1,173.3 сая, Улсын Их хурлын гишүүдийн зээлийн үлдэгдэл 1,956.2 сая, Хүнс, хөдөө аж ахуйн сайд /хуучнаар/, Хөдөлмөрийн сайд /хуучнаар/-ын тушаалуудаар олгосон 26,490.4 сая төгрөгийн зээлүүдийн эргэн төлөлт хангалтгүй байна. Мөн зээлийн нэгдсэн програм байхгүй, зөвхөн “MS-Excel” програмаар тооцооллыг гүйцэтгэж байгаа нь зээлийн үйл ажиллагаанд тавих хяналтыг сулруулж байна.

Шийдвэрлэсэн нь: Хугацаа хэтэрсэн зээлийг барагдуулан авлагыг бууруулан, эргэн төлөлтийн хэрэгжилтэнд хяналт тавих, зээлийн нэгдсэн програмтай болох талаар зөвлөмж өгөх.

Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас Аж үйлдвэр /хуучнаар/-ийн сайдын 2016 оны 25 дугаар тушаалын дагуу Хэнтий аймгийн Бор-Өндөр суманд барих “Газрын тос боловсруулах үйлдвэр”-ийн бэлтгэл ажилд шаардлагатай санхүүжилт болох 1,500.0 сая төгрөгийг “Аж үйлдвэрийн цогцолбор” ТӨХК-д хүүгүй, барьцаа хөрөнгөгүйгээр зээл олгосон байна.

Шийдвэрлэсэн нь: Гэрээг шинэчлэн байгуулж, зээлийн эргэн төлөлтийн баталгааг хангуулах талаар зөвлөмж өгөх.

2.9.7 Хөрөнгө оруулалтын талаар

2016 оны Санхүүгийн нэгтгэсэн тайланд авлагаар тусгагдсан “Мон инжбар” ХК-аас авах 224.2 сая төгрөгийн /2011 онд үүссэн “Ховд аймагт баригдаж байгаа хөдөө, аж ахуйн гаралтай бүтээгдхүүн үйлдвэрийн цэвэрлэх байгууламж барих” зориулалттай/ авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Авлагыг барагдуулах арга хэмжээ авах, тооцоо нийлж, баталгаажуулах талаар зөвлөмж өгөх.

2.9.8 Цалингийн талаар

Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яамны аппарат нь ажилчдынхаа цагийн бүртгэлийг хурууны хээгээр хийдэг боловч цалинг тооцохдоо цагийн бүртгэлийг үндэслэдэггүйгээс нийт давхардсан тоогоор 49 албан хаагчдад 1.9 сая төгрөгийн цалинг өвчтэй, чөлөөтэй, албан томилолттой үетэй давхардуулж олгосон байна.

Шийдвэрлэсэн нь: Албан хаагчдын цалинг баталгаажуулсан цагийн бүртгэлийг үндэслэн олгож байх, алдаа зөрчлийг давтан гаргахгүй талаар аудитын зөвлөмж өгөх.

2.9.9 Өмнөх зөвлөмжийн биелэлтийн талаар

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2015 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланд Үндэсний аудитын газраас хийсэн аудитаар 102,590.3 сая төгрөгийн 5 зөвлөмж, 30,354.9 сая төгрөгийн албан шаардлага өгснөөс 3.7 сая төгрөгийн 1 зөвлөмжийг биелүүлж, 102,586.6 сая төгрөгийн 4 зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, 27,354.9 сая төгрөгийн албан шаардлага нь хэрэгжиж, 3,000.0 сая төгрөгийн албан шаардлагыг биелүүлээгүй, тайлант онд зөрчлийг давтан гаргасан нь тус яамны удирдлага харьяа байгууллагад тавих дотоод хяналт сул, хариуцлагагүй байгаатай холбоотой байна.

Шийдвэрлэсэн нь: Урьд оны аудитын зөвлөмж, албан шаардлагыг биелүүлээгүй албан тушаалтанд хариуцлага тооцох албан шаардлага өгөх.

2.9.10 Алдаа, зөрчлийн талаар

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2016 оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа зөрчил 519,828.4 сая төгрөг бөгөөд энэ нь материаллаг байдлын түвшингээс 516,284.6 сая төгрөгөөр илүү байна.

2.9.11 Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны харьяа байгууллагуудын 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар гарсан зөрчлүүдийн талаар

ХХААХҮЯ-ны аппарат:

Томилолтын 6.2 сая төгрөгийн тооцоо хийгээгүй, батлагдсан төсвөөс хэмнэгдсэн 50.0 сая төгрөгийг Засгийн газрын байр ашиглалтын нэгдсэн захиргаанд 45.1 сая төгрөг, “Доктор авто сүлжээ” ХХК-нд 4.9 сая төгрөгийг шилжүүлж авлагаар бүртгэсэн, Төрийн нарийн бичгийн даргын Цалин тогтоох тухай 2016 оны Б/21 дугаар тушаалд Төрийн захиргааны 5 албан хаагчид мэргэшлийн зэргийн нэмэгдэл олгохоор баталсан, 14.0 сая төгрөгийн шатахууны зардлыг шууд зардалд бичсэн, томилолтын 10.7 сая төгрөгийн тооцоо нийлж баталгаажуулаагүй гэх мэт зөрчил дутагдлууд илэрч **“Зөрчилгүй”** санал, дүгнэлт авсан байна.

Тариалан эрхлэлтийг дэмжих сан:

Тайлант онд 53,290.2 сая төгрөгийн авлага, 31,876.6 сая төгрөгийн өглөгийн тооцоог нийлж баталгаажуулаагүй, 66,397.3 сая төгрөгийн авлага хугацаа хэтэрсэн, бараа материалын тайланд нийт 476.4 сая төгрөгөөр илүү тайлагнасан, 241.3 сая төгрөгийн усалгааны системийг бүртгэлд тусгаагүй, нээлттэй тендер шалгаруулалгүй 1,978.0 сая төгрөгийн ургамал хамгаалалын бодис худалдан авсан гэх мэт зөрчлүүд илэрч **“Хязгаарлалттай”** санал, дүгнэлт авсан байна.

Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан:

Тайлант хугацаанд авлагын 122,488.1 сая төгрөгийн, өглөгийн 140,150.7 сая төгрөгийн тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, Хөгжлийн банкинд 88,914.6 сая төгрөгийн өглөгтэй боловч 24.4 сая төгрөгөөр өглөгийг илүү бүртгэсэн, “МБМХ” ХХК-д 2013 онд 1,380.0 сая төгрөг, “Селенит” ХХК-нд 3,000.0 сая төгрөг, “Хустын хойд салаа” ХХК-д 2011 онд 400.0 сая төгрөг, “Ургац хангай” ХХК-д 400.0 сая төгрөгийн төслүүд хэрэгжээгүй, үйл ажиллагаа эрхлээгүй байхад төлбөрийг барагдуулаагүй, холбогдох арга хэмжээ аваагүй, ТБОНӨХБАҮХАТ хуулийн харьцуулалтын арга хэрэглэлгүй “Дарханстар” ХХК-д 21.8 сая төгрөг, “Вайрал партнерс” ХХК-д 23.7 сая төгрөгийн гэрээ байгуулсан гэх зэрэг зөрчлүүд нь аудитын оршин байх, эрх ба үүрэг, хэмжилт, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул **“Хязгаарлалттай”** санал, дүгнэлт авсан байна.

Малын удмын сан:

Хөрөнгийн тооллогоор 5.9 сая төгрөгийн үндсэн хөрөнгө, 4.2 сая төгрөгийн бараа материал дутагдсан, үндсэн үйл ажиллагааны орлогыг 6.5 сая төгрөгөөр дутуу төвлөрүүлсэн гэх зэрэг зөрчлүүдэд **“Хязгаарлалттай”** санал, дүгнэлт авсан байна.

Хөдөө аж ахуйн бирж:

Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль зөрчин 193.1 сая төгрөгийн клирингийн програмын сургалт, 63.7 сая төгрөгийн хууль зүйн зөвлөх үйлчилгээ үзүүлсэн, 38.6 сая төгрөгийн аж ахуйн нэгжийн орлогын албан татварыг төсөвт төвлөрүүлээгүй, гадаад томилолтын удирдамжгүй 19.7 сая төгрөгийг зарцуулсан, шаардлага хангаагүй НББ-ийн бодлогын баримт бичигт 15.0 сая төгрөг зарцуулсан, зориулалтын бус эх үүсвэрээс 176.4 сая төгрөг зарцуулсан, хүчин төгөлдөр бус баримтаар 80.8 сая төгрөгийг зарцуулсан гэх зэрэг зөрчлүүдэд ***“Хязгаарлалттай”*** санал, дүгнэлт авсан байна.

Говь-алтай аймгийн ХХААГ:

Үндэслэлгүйгээр 0.98 сая төгрөгийн шатахуун илүү зарцуулсан, ажилчдаас 0.26 сая төгрөгийн НДШ-ийн тооцоог илүү суутган авсан, 2.7 сая төгрөгийг зөрүүтэй анхан шатны баримтаар зарцуулсан, хуруу шилний үнийг буцаан олгохдоо 0.47 сая төгрөгийг илүү олгосон, үндэслэлгүйгээр 3.4 сая төгрөгийг “Буудайн хийморь” ХХК-д шилжүүлсэн, 0.9 сая төгрөгийг авлагаар тусгаагүй, ажилчдын цалингаас хууль бусаар 4.9 сая төгрөгийг суутгасан, царцаа устгалтын ажилд 93.5 сая төгрөгийг компаниудад шилжүүлсэн боловч зарцуулалтыг нотлох баримт байхгүй гэх зэрэг зөрчил илэрч ***“Сөрөг”*** санал дүгнэлт авсан ба тус байгууллагын 3 ажилтанд сахилгын шийтгэл ногдуулсан байна.

Мал эмнэлэг, үржлийн газар:

Нийт 45.1 сая төгрөгийн томилолт, тээвэр шатахууны зардлыг бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээ, бараа үйлчилгээний бусад зардлын ангилалаас гаргасан зөрчил нь материаллаг түвшинд хүрээгүй тул ***“Зөрчилгүй”*** санал, дүгнэлт авсан байна.

Мал хамгаалах сан:

Тайлант онд зээл болон зээлийн хүүгийн эргэн төлөлт 58 хувьтай, санхүүгийн үр дүнгийн тайланд түрээсийн орлого 227.8 сая төгрөг байх атал 40 хувийг төвлөрүүлж байгаа нь түрээсийн төлбөрийн эргэн төлөлт хангалтгүй зэрэг зөрчил нь материаллаг түвшинд хүрээгүй тул ***“Зөрчилгүй”*** санал, дүгнэлт авсан байна.

Биокомбинат ТӨААТҮГ:

Тайлант онд 19.2 сая төгрөгийн худалдан авалтаас татвар суутган тооцоогүй, 1.7 сая төгрөгийн баримтын бүрдэл дутуу, 40.2 сая төгрөгийн авлагын тооцоо нийлээгүй байгаа зэрэг зөрчлүүд нь материаллаг түвшинд хүрээгүй тул ***“Зөрчилгүй”*** санал, дүгнэлтийг авсан байна.

Тариалан эрхлэлтийг дэмжих сан КР-1 төсөл:

КР-1 төслийн хуримтлалаас нийт 41.1 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан, он удаан жил дамжсан нийт 33,229.6 сая авлагын үлдэгдэлтэй, 2,910.0 сая төгрөгийн авлагыг тооцоо нийлж баталгаажуулаагүй, эзэн холбогдогч нь тодорхойгүй 4.2 сая төгрөгийн өглөг байна.

Тариалан эрхлэлтийг дэмжих сан КР-2 төсөл:

Тариалан эрхлэлтийг дэмжих сангаас авах авлага 5,222.4 сая төгрөг, Сангийн яамнаас 53.6 сая төгрөг, Монгол банкны дансны хүүгийн зөрүүгийн авлага 5.4 сая төгрөг, төлбөртэй

үйлчилгээний авлага, 2,236.8 сая төгрөгийн авлагууд он удаан жил болсон, 2,226.4 сая төгрөгийн авлагын тооцоо нийлж баталгаажуулаагүй.

Бага оврын тракторын зээл төсөл:

Нийт 52,068.6 сая төгрөгийн авлагын тооцоо нийлж баталгаажуулаагүй, 57.2 сая төгрөгийн хөрөнгө дутсан, 251.8 сая төгрөгийн эзэн холбогдогч нь тодорхойгүй авлага байна.

2.10 АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас 2011-2015 онд олгож байсан зээлийн эргэн төлөлт хангалтгүй байгаагаас найдваргүй авлага үүсэх эрсдэл гарахаар байна.

Мөн Сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүүгийн тайланг нэгтгэн гаргаж байгаа “Э-тайлан” програм хангамж хэвийн ажиллаагүй, Санхүүгийн нэгтгэсэн тайланд тайлагнасан хөрөнгийн санхүүжилт, урсгал зардал, гадаад зээлийн санхүүжилт, нэмэлт санхүүжилт болон бусад холбогдох тооцоог Сангийн яамтай тооцоо бүрэн нийлж баталгаажуулаагүй, Төв төрийн сангийн төсвийн хэлбэлзлийн тайлан эцэслэгдээгүй, нэгтгэлийн “Э-тайлан” програмаас хэвлэгдэж буй санхүүгийн байдлын тайланд Засгийн газрын хувь оролцооны дүн дутуу татагдсан зэрэг нь сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүүгийн нэгтгэсэн тайланг ЗГСНТ-д нэгтгүүлэхэд зарим тоон мэдээлэл өөрчлөгдөх эрсдэл үүсгэх магадлалтай байна.

2.11 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АСУУДЛУУД

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын санхүүгийн тайланд нэгтгэгдэж байгаа Тариалан эрхлэлтийг дэмжих сан, Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан, Мал хамгаалах сан, Хөдөө аж ахуйн бирж зэрэг байгууллагуудтай холбоотой зөрчил дутагдал их гарч байгаа тул дараагийн аудитаар дээрх байгууллагуудад гүйцэтгэлийн болон эрсдэлийн аудит хийх шаардлагатай байна.

2.12 АУДИТААР ИЛЭРСЭН ЗӨРЧИЙН НЭГТГЭЛ

